

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017 оны 4 дүгээр сарын 30

№

Улаанбаатар хот

“ӨНДӨРХААН” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджавын гудамж, 5/3 байранд 2018 оны 4-р сарын 30-ны өдрийн 13:00 цагт эхлэж, нийт 45 минут үргэлжлэн, 13:45 цагт өндөрлөв.

Хуралд оролцсон гишүүд:

Л.Золбаяр /Хувьцаа эзэмшигч/
Н.Улаанхүү /Хурлын дарга/
Х.Баатархүү /Гүйцэтгэх захирал/
Б.Эрдэнэжаргал /Тооллогын комисс/
С.Сувд-Эрдэнэ /Тооллогын комисс/
Н.Төгөлдөр /Тооллогын комисс/

Залруулга: ТУЗ-ийн 2018 оны 3-р сарын 19-ний 02 тоот тогтоол дээр Хурлын дарга болон Тооллогын комиссын даргын нэрсийг андууран бичсэн алдаа гарсан тул энд залруулга хийв. Хурлын даргаар Г.Хатанболд гэснийг Н.Улаанхүү, Тооллогын комиссын даргаар Д.Баярсайхан гэснийг Б.Эрдэнэжаргал болгон өөрчлөв.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэжаргал хурлын ирцийг танилцуулав. Нийт 111,879 ширхэг бүхий энгийн хувьцаатай, үүнээс саналын эрх бүхий 91,443 ширхэг бүхий хувьцааг эзэмшдэг хувьцаа эзэмшигч хуралд хүрэлцэн ирсэн тул хурлын ирц 81.73%-тай байна. Хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхи хуралд ирсэн тул энэхүү ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцно. Хуралд ирсэн хувьцаа эзэмшигч:

№	Хувьцаа эзэмшигчийн овог нэр	Хувьцааны тоо ширхэг	Эзэмшил хувь
1	Лхагвагийн Золбаяр	91,443	81.73%
Нийт		91,443	81.73%

Хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 3-р сарын 19-ний өдрийн 02 тоот тогтоол болон хурлын дэгийн дагуу дараах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэв. Үүнд:

Хэлэлцэх асуудал 1: Компанийн 2017 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Н.Улаанхүү: Өндөрхаан ХК нь 2012 оноос хойш үндсэн үйл ажиллагаагаа явуулаагүй бөгөөд компанийн үйл ажиллагааг сэргээх, хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс газар тариалангийн салбарт үйл ажиллагаа явуулж буй Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх талаар 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн. Мөн нэгдэхтэй холбоотой хөрөнгийн үнэлгээ, аудит зэргийг хийлгэсэн. Мөн, 2017 оны 11-р сард компанийн гүйцэтгэх захирлыг өөрчилж, Тэмүүжин хүнс ХХК-ийн хүсэлтийг үндэслэн Хорлоогийн Баатархүүг ТУЗ-өөс гүйцэтгэх захирлаар томилсон.

Санхүүгийн тайлангийн хувьд 2017 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт хөрөнгө 34,509,800 төгрөг, ямар нэгэн өр төлбөргүй, эздийн өмч 34,509,800 төгрөг, хуримтлагдсан алдагдал 11,963,200 төгрөг байна. 2017 онд үйл ажиллагаа явуулаагүй учраас борлуулалтын орлого олоогүй, үйл ажиллагааны зардал 1,025,500 төгрөг гарсан нь аудитын зардал, гишүүнчлэлийн хураамж байсан ба 19,755,300 төгрөгийн найдваргүй авлагыг хааж, 15,146,200 төгрөгийн бараа материал акталсан. 2017 оны санхүүгийн

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

тайланд Сүлд-Аудит ХХК-аар аудит хийлгэж, дүгнэлт гаргуулсантай хурлын материалаас танилцана уу. Компанийн хөрөнгийн үнэлгээг 2017 оны 8-р сарын 31-ний байдлаар Оюу-Эрдэм Аудит ХХК-аар хийлгэж, хөндлөнгийн үнэлгээчид Өндөрхаан ХК-ийн нэгж хувьцааны бодит үнэ цэнийг 310 төгрөгөөр тогтоосон. Төлөвлөгөө ёсоор бид 2017 ондоо багтааж Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх танилцуулга материалыг СЗХ болон МХБ-д өгөх ёстой байсан боловч Тэмүүжин хүнс ХХК дээр дотоод асуудал гарсан тул өдий болтол хойшлогдоод байна. Манай компанийн хувьд Тэмүүжин хүнс ХХК-тай байгуулсан Нэгдэх гэрээ журмын дагуу хөрөнгийн үнэлгээ, аудитыг хийлгэж, мөн хуулийн дүгнэлт гаргах материалуудаа бэлдэж, төлөвлөгөөний дагуу хангалттай ажилласан гэж дүгнэж байна.

Л.Золбаяр: Компанийн нөхцөл байдлыг мэдэж байгаа болохоор үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах саналтай байна.

Хэлэлцэх асуудал 2: Компанийн 2017 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Н.Улаанхүү: Өндөрхаан ХК нь 2017 онд бизнесийн ашигт ажиллагаа явуулаагүй учраас энэ онд ногдол ашиг тараах боломжгүй гэж ТУЗ-өөс шийдвэрлэснийг танилцуулъя.

Л.Золбаяр: Компанийн нөхцөл байдал сайнгүй байгаа тул ТУЗ-ийн шийдвэрийг дэмжиж байна.

Хэлэлцэх асуудал 3: Компанийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг танилцуулах

Н.Улаанхүү: 2018 онд Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас баталсан Нэгтгэх гэрээ, журмын дагуу Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн, амжилттай гүйцэтгэж дуусгах төлөвлөгөөтэй байна. Үүнд Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас баталсан Нэгтгэх гэрээ, журам болон хурлаас гарсан дараах тогтоол шийдвэр дээр үндэслэн ажиллана. Үүнд:

1. Өндөрхаан ХК-нд Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрч, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл, нэгтгэх гэрээний төслийг батлаж, аудитаар баталгаажуулсан дүнг эцэслэн оруулах эрхийг ТУЗ-д олгосон Тогтоол №01
2. Өндөрхаан ХК-нд Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахыг зөвшөөрсөн, мөн нэмж хувьцаа гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхаар баталсан Тогтоол №02
3. Өндөрхаан ХК-ийн хаяг, дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батласан Тогтоол №03

Л.Золбаяр: Компанийн үйл ажиллагааг сэргээх, нийт хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс үйл ажиллагаа нь амжилттай явж буй Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх ажиллагааг хурдан гүйцэтгэж дуусгахыг миний зүгээс 100% дэмжиж байна. Нэгтгэх ажлаа нэн яаралтай дуусгах хэрэгтэй байна.

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хэлэлцэх асуудал 4: ТУЗ-ийн гишүүдийг сонгох

Н.Улаанхүү: Энэ жил ТУЗ-д нэр дэвшигчид бүгд өмнөх оноос улиран дэвшиж буй бөгөөд нэр дэвшигчдийг хурлын материалын дагуу танилцуулъя. /Товч намтрыг танилцуулав/

Ердийн гишүүнд нэр дэвшигчид:

- Д.Баярсайхан
- Г.Лхамсүрэн
- Н.Улаанхүү
- Г.Хатанболд
- Г.Одонтуяа
- Д.Баттулга

Хараат бус гишүүдэд:

- Ө.Хангал
- М.Нямсүрэн
- Г.Даваа-Очир

Хэлэлцэх асуудал 5: ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг хэлэлцэн батлах

Н.Улаанхүү: Компани 2017 онд үйл ажиллагаа явуулж орлого олоогүй мөн 2018 онд үндсэн үйл ажиллагаагаа явуулахгүй учраас ТУЗ-ийн гишүүдэд цалин урамшуулал олгох боломжгүй байна.

Л.Золбаяр: Энэ саналыг дэмжиж байна.

Хэлэлцэх асуудал 6: Компани нэгтгэх ажлын явцыг хэлэлцэх

Н.Улаанхүү: Компани нэгтгэх ажлын явцыг дээр бараг бүгдийг ярьчихлаа, энэ ажил нь 2018 оны чухал төлөвлөгөөт ажил болоод байна. Тиймээс энд нэг асуудлыг хөндөж, шийдүүлмээр байна. Бид Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанид Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх шийдвэрийг гаргаж, Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг Нэгтгэх гэрээ, журмыг баталсан. Харин нэгтгэх үйл явц төлөвлөж байснаас сунжирсан тул ээлжит бус хурлаас гарсан Тогтоол №01-д дараах өөрчлөлтийг оруулж, шинэчлэн батлах шаардлагатай гэдэг саналыг оруулж байна. Үүнд:

1. Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас баталсан Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх гэрээ, журамд хоёр компанийн 2017 оны 4-р улирлын аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангийн дүнгүүдийг оруулж эцэслэн батлах эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлд олгосугай.
2. Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх гэрээ, журмыг эцэслэн батлах, нэгтгэх үйл ажиллагааг холбогдох хууль, журамд заасны дагуу хэрэгжүүлж, эрх бүхий байгууллагуудаар шийдвэрлүүлэх, Өөрчлөн байгуулах коммисыг байгуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Л.Золбаяр: Нэгтгэх ажил хойшилж он дамнасан тул 2017 оны 3-р биш 4-р улирлын тайлангаарх дүнгүүдийг оруулах нь зүйтэй гэж үзэж, саналыг дэмжиж байна. Өмнөх ээлжит бус хурлаар Нэгтгэх гэрээ журмыг 25/75 хувийн харьцаагаар хувь нийлүүлсэн хөрөнгөд үндэслэн Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэхээр баталсан тул аудитын дүн гарсны дараа Нэгтгэх гэрээ журмыг эцэслэн батлахыг ТУЗ-д даалгаж хариуцуулах нь асуудалгүй гэж бодож байна.

Хэлэлцэх асуудал 7: Өндөрхаан ХК-ийн албан ёсны хаягийн өөрчлөлтийг зөвшөөрөх

Н.Улаанхүү: Өндөрхаан ХК-ийн 2017 оны 10-р сарын 16-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар компанийн албан ёсны хаягийг нэгдэж буй Тэмүүжин хүнс ХХК-ийн хаяг руу шилжүүлж, дүрэмд өөрчлөлт оруулах шийдвэр гарсан ч эрх бүхий байгууллагаас тодорхой хаяг дурдсан байх ёстой гэсэн тул энэ ажил хийгдээгүй байна. Тиймээс энэ хурлаар Тэмүүжин хүнс ХХК-ийн хаягийг Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, 29, 58 тоот, утас 95959529 тодорхой дурдсан тогтоол гаргах хэрэгтэй байна.

Л.Золбаяр: Болж байна, тогтоолоо гаргаад баталъя, дүрэмдээ ч тусгая. Өөрчлөлтийг цаг хугацаанд нь батгаж хийлгэе.

Хэлэлцэх асуудал 8: Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах

Н.Улаанхүү: Компанийн албан ёсны хаяг байршлын өөрчлөлтийг компанийн дүрэмд тусгаж батлах шаардлагатай байдаг. Тиймээс хаягийн өөрчлөлтийг хийлгэсний дараа дүрэмдээ тусгаж, дүрмээ хууль журамд заасан цаг хугацаанд багтаж Улсын бүртгэлд бүртгүүлэх хэрэгтэй байна. Харин өмнөх ээлжит бус хурлаас нэмэлт хувьцаа гаргах шийдвэр гаргасны дагуу дүрэмд өөрчлөлт оруулахыг СЗХ-ноос албан ёсоор шийдвэр гарсны дараа дүрэмд тусгах боломжтой гэдгийг анхаарна уу.

Л.Золбаяр: Өндөрхаан ХК-ийн Компанийн дүрэмд өөрчлөлт оруулахыг зөвшөөрч байна.

Хэлэлцэх асуудал 9: Бусад асуудал

Н.Улаанхүү: ХЭХ-аар хэлэлцэж батлуулах өөр асуудал байвал, мөн хэлэлцсэн асуудлуудаар асуулт асууж, санал бодлоо хэлнэ үү.

Хуралд оролцогчид танилцуулсан асуудалтай холбоотой нэмэлт санал, асуулт байхгүй гэснээр хэлэлцэх асуудлын танилцуулга хэсэг өндөрлөв. Мөн санал хураалт явагдаж, тооллогын комисс дүнгээ танилцуулж, улмаар Хурлын дарга хурлын тогтоол шийдвэрүүдийг танилцуулснаар хурал өндөрлөв.

Тооллогын комиссын дарга Б.Эрдэнэжаргал тооллогын дүнг танилцууллаа.

1. Өндөрхаан ХК-нд Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулахыг зөвшөөрөх, нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл, нэгтгэх гэрээний төслийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталж, эцэслэн батлах эрхийг ТУЗ-д өгөхөөр тогтов.

ӨНДӨРХААН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2. Өндөрхаан ХК-нд Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргахийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар батлав.
3. Өндөрхаан ХК-нд Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг одоогийн хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэхгүй байхийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан байна.
4. Өндөрхаан ХК-ийн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг хуралд оролцсон нийт хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар баталсан байна.

Шийдвэрлэсэн нь:

Шийдвэр 1: Компанийн 2017 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг зөвшөөрч батлав. /Тогтоол №1/

Шийдвэр 2: Компанийн ТУЗ-ийн гишүүдээр дараах байдлаар

Ердийн гишүүнээр

- Д.Баярсайхан
- Г.Лхамсүрэн
- Н.Улаанхүү
- Г.Хатанболд
- Г.Одонтуяа
- Д.Баттулга нарыг, мөн

Хараат бус гишүүдэд:

- Ө.Хангал
- М.Нямсүрэн
- Г.Даваа-Очир нарыг сонгов. /Тогтоол №2/

Шийдвэр 3: Компанийн ТУЗ-ийн 2018 оны зардлын төсвийг тэг төгрөгөөр батлав. /Тогтоол №3/

Шийдвэр 4: Өндөрхаан ХК-д Тэмүүжин хүнс ХХК-ийг нэгтгэх гэрээ, журамд 2017 оны 4-р улирлын дүнг тусгаж, эцэслэн батлах, хэрэгжүүлэх ажлыг ТУЗ-д хариуцуулахаар тогтов. /Тогтоол №4/

Шийдвэр 5: Өндөрхаан ХК-ийн харъяалал, албан ёсны хаягийг Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага тойруу, 29, 58 тоот, утас 95959529 болгож өөрчлөхөөр тогтов. /Тогтоол №5/

Шийдвэр 6: Өндөрхаан ХК-ийн дүрмийн төслийг батлав. /Тогтоол №6/

Хурлын тэмдэглэл хөтөлсөн: С.Сувд-Эрдэнэ

Хянасан: Н.Улаанхүү /Хурлын дарга/